



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ

<p>Хаяг: Архангай аймаг, Эрдэнэбулган сум. Аймгийн ЗДТГ-ын байр “А” корпус, 3 давхар зүүн жигүүр.</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр Утас: 70333141 Цахим хаяг: UlambayrD@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Байгалмаа Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn</p> <p>Аудитор: J.Mungunshagai Утас: Цахим хаяг: MungunshagaiJ@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.5.2 Авлага.....	11
3.5.3 Бараа материал.....	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	13
3.5.10 Орлогын данс.....	14
3.5.11 Зардлын данс.....	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	15
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	18
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал...20	20
Дараагийн аудитад сум хөгжүүлэх сангийн талаар, болон орон нутгийн орлогын төлөвлөлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.....	20
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	22
1. Авлагын данстай холбоотой асуудал:.....	22
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХСан	Орон нутгийн хөгжлийн сан
СХСан	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2-р баг,
Утас/Факс: (976) 7033 3141, И-мэйл: arkhangai@audit.gov.mn
Вэб сайт: www.audit.mn

**БАТЦЭНГЭЛ СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Ц.ЗОРИГТХҮҮ ТАНАА**

2021.02.31 № 142

Талай _____ -ны/№ _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp of the State Audit Agency of Mongolia is positioned in the center. It contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТЫН АГЫН ГЭРЭГ" (State Audit Agency of Mongolia) and the national emblem. A handwritten signature in black ink is written over the stamp.

Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	763,310.4	773,981.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	209,338.2	96,313.0
33	АВЛАГА	309,636.5	373,733.9
35	БАРАА МАТЕРИАЛ	244,335.8	303,934.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,188,342.9	5,500,366.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,188,342.9	5,500,366.7
39200	Биет хөрөнгө	4,090,141.6	5,403,355.4
39300	Биет бус хөрөнгө	98,201.3	97,011.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,951,653.3	6,274,347.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,951,653.3	6,274,347.7
51	Засгийн газрын хувь оролцоо	4,951,653.3	6,274,347.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,975,885.8	1,975,885.8
51200	Хуримтлагдсан үр дүн	1,899,906.1	3,222,600.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,075,861.4	1,075,861.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,951,653.3	6,274,347.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,783,128.7	4,190,212.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	151,101.6	169,046.8
110	Орлогын албан татвар	89,520.4	111,029.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	89,520.4	111,029.5
113	Хөрөнгийн албан татвар	4,703.0	5,010.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,878.2	53,007.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	236,582.1	1,706,366.4
120	Нийтлэг татварын бус орлого	236,582.1	1,706,366.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,395,445.0	2,314,799.6

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,783,622.2	2,745,543.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,783,622.2	2,745,543.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,270,494.7	2,684,949.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,437,635.9	1,725,064.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,221.9	228,846.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,067.4	81,861.5
2104	Хангамж, бараа материалын зардал	86,460.8	82,330.3
2105	Нормативт зардал	95,784.3	122,833.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,974.2	7,985.0
2107	Томилолт, зочны зардал	8,135.0	2,576.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,433.5	57,988.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	359,781.7	375,462.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	513,127.5	60,486.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-493.5	1,444,777.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	64,027.4	122,083.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-64,520.8	1,322,694.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,624,961.4	2,988,475.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	151,101.6	169,046.8
110	Орлогын албан татвар	89,520.4	111,029.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	89,520.4	111,029.5
113	Хөрөнгийн албан татвар	4,703.0	5,010.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,878.2	53,007.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,071.5	9,583.8

1181	Газрын төлбөр	28,705.1	25,048.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	20,101.6	18,375.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,414.8	46,549.0
120	Нийтлэг татварын бус орлого	78,414.8	46,549.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,395,445.0	2,772,879.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,439,216.0	2,854,972.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,439,216.0	2,854,972.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,926,380.6	2,336,406.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,419,306.4	1,724,746.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,342.5	229,165.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,276.7	90,006.3
2104	Хангамж, бараа материалын зардал	60,491.5	77,194.6
2105	Нормативт зардал	95,376.2	79,781.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,905.0	15,420.0
2107	Томилолт, зочны зардал	7,725.9	2,965.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,145.0	61,709.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,811.3	55,417.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	512,835.5	518,566.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	185,745.4	133,502.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,664.8	150,527.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,664.8	150,527.9
2200	Дотоод эх үүсвэрээр	48,664.8	150,527.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-48,664.8	-150,527.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-19,000.0	-96,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	19,000.0	96,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	118,080.5	-113,025.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,257.6	209,338.2
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	209,338.2	96,313.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,016,174.2	5,016,174.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,016,174.2	5,016,174.2
9	Тайлант үеийн үр дүн	-64,520.8	-64,520.8
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,951,653.3	4,951,653.3
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,951,653.3	4,951,653.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,951,653.3	4,951,653.3
19	Тайлант үеийн үр дүн	1,322,694.4	1,322,694.4
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,274,347.7	6,274,347.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
-----	----------	------------	-----------------------------

Батцэнгэл сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,691,808.50	2,534,435.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,350,542.90	2,295,563.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,313,169.20	2,265,976.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,717,915.70	1,711,646.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,010.00	227,527.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,251.70	88,506.32
2104	Хангамж, бараа материалын зардал	66,896.60	57,680.81
2105	Нормативт зардал	99,269.10	76,781.32
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,420.00	12,420.00
2107	Томилолт, зочны зардал	3,451.70	2,965.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,304.60	51,798.87
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,649.80	36,649.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,373.70	29,586.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,373.70	29,586.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,853.40	142,872.11
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	178,412.20	96,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,691,808.50	2,412,677.78
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,705,400.40	1,668,502.80
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,705,400.40	1,668,502.80
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	619,092.80	673,861.33
320001	Орон нутгийн төсвөөс	558,346.30	613,114.83
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	60,746.50	60,746.50
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,000.00	29,092.34
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	40,000.00	29,092.34
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	327,315.30	41,221.30
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	182,882.20	36,754.30
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.00	4,467.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		151,221.98
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		29,464.18
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,024.00	1,024.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	6	6
610001	Төсвийн байгууллага	6	6
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	144.5	144.5
620001	Удирдах ажилтан	13	13
620002	Гүйцэтгэх ажилтан	88.5	88.5
620003	Үйлчлэх ажилтан	33	33
620004	Гэрээт ажилтан	10	10
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	729	729
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	513	513
630001	Төрийн өмчит ЕБС	513	513
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	216	216
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	216	216
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	144.5	144.5
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	52.5	52.5
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	14	14
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	12	12

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21	21
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31	31
650010	Гэрээт ажилтан	2	2
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,085.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,085.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,085.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,637.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	19,852.5
2105	Нормативт зардал	3,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,910.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,085.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,085.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,085.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	109.7
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,657.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,318,600.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ц.Зоригтхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасах болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэв.

Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны зорилго нь Нутгийнхаа байгаль орчинг хамгаалан, хүний ба бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг жигд хөгжүүлсэн, нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх сум болох” зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Ажлын байрыг 2-3 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- ✓ Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Батцэнгэл сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Батцэнгэл сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,167,140.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 41,671.4 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 209,338.1 мянга, эцсийн үлдэгдэл 96,312.9 мянган төгрөг болж 113,025.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Төрийн сангийн харилца	209,338.1	96,312.9	-113,025.2
Үүнээс байгууллагын төрлөөр			
Орон нутгийн ерөнхий орлого	58,116.2	66,848.8	8,732.6
Орон нутгийн хөгжлийн сан	81,316.9	19,980.3	-61,336.6
Сум хөгжүүлэх сан	69,905.0	9,483.8	-60,421.2
Дүн	209,338.1	96,312.9	-113,025.2

Эх сурвалж: Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 113,025.2 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэлээс зарцуулсантай холбоотой байна.

3.5.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 373,733.8 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 64,097.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Орон нутгийн ерөнхий орлого	3,886.6	3,886.6	-
Сум хөгжүүлэх сан	305,749.8	369,847.2	64,097.4
Дүн	309,636.4	373,733.8	64,097.4

Эх сурвалж: Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 64,097.4 мянган төгрөгөөр өссөн бол Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд 3,886.6 мянган төгрөгийн 15-22 жилийн насжилттай авлага байна.

Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны 3,886.6 мянган төгрөгийн авлагын 2,412.0 мянган төгрөг нь 1998 онд сум хөгжүүлэх сангаас олгосон 3 иргэнтэй холбоотой, 1,474.6 мянган төгрөгийн авлага нь 2005 онд үүссэн эзэн холбогдогч нь нас барсан авлагууд байна. 1998 оны авлагыг хууль хяналтын байгууллагаар шийдүүлэх хүсэлтийг тавьсан боловч тухайн зээлийг нотлох баримт материал, гэрээ байхгүй гэсэн шалтгаанаар буцаагдсан байна.

Харин Сум хөгжүүлэх сангийн 369,847.8 мянган төгрөгийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 243,388.9 мянган төгрөг буюу 65.8 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 126,466.1 мянган төгрөг буюу 34.2 хувь нь хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл

байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэхээр хугацаатай мэдэгдэл хүргүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн ерөнхий орлогын дансны 3,886.6 мянган төгрөгийн авлаганд албан шаардлага хүргүүлээ.
- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл болох нийт 126,466.1 мянган төгрөгөнд зөвлөмж хүргүүлээ.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 244,335.8 мянга, эцсийн үлдэгдэл 303,934.1 мянган төгрөг болж, 59,598.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,927.2	29,513.9	25,586.7
Эм боох материал	3,987.2	29,513.9	25,526.7
Хангамжийн материал	239,758.6	273,770.2	34,011.6
Мал амьтад	650.0	650.0	0.0
Дүн	244,335.8	303,934.1	59,598.3
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	86,772.4	93,117.9	6,345.5
ЗДТГ	34,986.0	35,852.8	866.8
ИТХ	959.2	949.8	-9.4
Соёлын төв	38,056.2	42,111.6	4,055.4
Цэцэрлэг	32,920.0	47,167.1	14,246.6
ЭМТ	50,641.5	84,734.9	34,093.4
Дүн	244,335.8	303,934.1	59,598.3

Эх сурвалж: Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын үлдэгдлийн 30.6 хувь буюу 93,117.9 мянган төгрөг нь Ахлах сургуулийн, 11.8 хувь буюу 35,852.8 мянган төгрөг нь ЗДТГ-ийн, 15.5 хувь буюу 47,167.1 мянган төгрөг нь Хүүхдийн цэцэрлэгийн, 27.9 хувь буюу 84,734.9 мянган төгрөг нь ЭМТөвийн, 13.9 хувь буюу 42,111.6 мянган төгрөг нь Соёлын төвийн бараа материалууд байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 223,027.3 мянган төгрөгийн, хандив тусламжаар 84,083.3 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 1,027.6 мянган төгрөгийн материал авсан бөгөөд 248,539.9 мянган төгрөгийн материалыг зарцуулж нийт 303,934.1 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Ахлах сургуулийн бараа материалын дэлгэрэнгүй тайланд 350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаад аудитаас зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.
- Эрүүл мэндийн төвийн СТАудитаар 3,137.5 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгслийг орлогод авч тайланд залруулга хийсэн

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,188,342.8 мянга, эцсийн үлдэгдэл 5,500,366.6 мянган төгрөг болж, 1,312,023.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,090,141.5	5,403,355.3	1,313,213.8
Биет бус хөрөнгө	98,201.3	97,011.3	-1,190.0
Дүн	4,188,342.8	5,500,366.6	1,312,023.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	1,710,471.3	1,611,586.9	-98,884.4
ЗДТГ	1,016,572.4	2,330,243.6	1,313,671.2
ИТХ	287.9	3,965.0	3,677.1
Соёлын төв	748,954.2	741,990.8	-6,963.4
Хүүхдийн цэцэрлэг	212,494.4	295,591.8	83,097.4
ЭМТ	499,562.6	516,988.5	17,425.9
Дүн	4,188,342.8	5,500,366.6	1,312,023.8

Эх сурвалж: Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28,444.8 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хандиваар авсан 64,873.6 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 1,541,735.5 мянган төгрөгийн, нийт 1,635,053.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол тайлант онд хөрөнгө актлаж устгаагүй, бусад байгууллагад шилжүүлээгүй байна.

Нийт хөрөнгийн 42.4 хувь буюу 2,330,243.6 мянган төгрөг нь ЗДТГазрын, 29.3 хувь буюу 1,611,586.9 мянган төгрөг нь Ахлах сургуулийн, 13.5 хувь буюу 741,990.8 мянган төгрөг нь Соёлын төвийн, 9.4 хувь буюу 516,988.5 мянган төгрөгийг ЭМТөвийн хөрөнгүүд эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 130 нэр төрлийн нийт 130,053.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаад аудитаас зөвлөмж хүргүүлэн ажиллаа.*
- Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 56 нэр төрлийн 32,014.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил байгаа бөгөөд аудитаас тус хөрөнгүүдийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллах зөвлөмж хүргүүлсэн байна.*

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,951,653.3 мянга, эцсийн үлдэгдэл 6,274,347.7 мянган төгрөг болж, 1,322,694.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/
----------	----------------	-----------------	---------------------

Засгийн газрын оруулсан капитал	1,975,885.8	1,975,885.8	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,899,906.1	3,222,600.5	1,322,694.4
Өмнөх үеийн үр дүн	1,899,906.1	1,899,906.1	0.0
Тайлант үеийн үр дүн		1,322,694.4	1,322,694.4
Хөрөнгийн дахин үнэлгээний	1,075,861.4	1,075,861.4	0.0
Дүн	4,951,653.3	6,274,347.7	1,322,694.4

Эх сурвалж: Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 1,322,694.4 мянган төгрөгөөр өсч тайлагнагдсан байна.

3.5.10 Орлогын данс

Батцэнгэл сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 4,190,212.8 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 1,407,084.1 мянган төгрөгөөр өссөн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 169,046.8 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 1,706,366.4 мянган төгрөг байна. Үүнээс: төсөвт байгууллагын өөрийн орлого 9,318.7 мянган төгрөг, нийтлэг татварын бус орлого 4,805.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,691,720.0 мянган төгрөг, бусад орлого буюу нэр заагдаагүй бусад орлого 522.3 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 2,314,799.6 мянган төгрөг байна. Үүнээс: Улсын төсвөөс 1,699,402.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 73,871.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 512,433.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 29,092.3 мянган төгрөг байна.

3.5.11 Зардлын данс

Батцэнгэл сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 2,745,435.3 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 122,083.1 мянган төгрөг нийт 2,867,518.4 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 1,322,694.4 мянган болж 1,258,173.6 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант жилд 454,732.3 мянган төгрөгийн санхүүжилт, 3,347.7 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ахлах сургууль нь тайлант онд 33 ААН-тэй хийсэн 75,442.5 мянган төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 5 аж ахуй нэгж 185.1 мянган төгрөгийн борлуулалтаа цахим төлбөрийн баримтын системд сургуулийн худалдан авалтаар бүртгээгүй байсанд аудитаас зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн
2. Хүүхдийн цэцэрлэгийн цалин давтан тооцооллоор байгууллагын эрхлэгчид 1, 2-р сард 375.4 мянган төгрөгийн үр чадварын нэмгдэл хөлс илүү тооцож олгосон мөн түлш халаалтын зардлын хэмнэлтээс 600.0 мянган төгрөгийн түлш нөөцөлсөн зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоолоо.
3. ЭМТ-ийн тогтмол зардал болон тээвэр, шатахуун, томилолтын зардлуудад түүврийн сорил хэрэгжүүллээ. Сорилоор гэрэл цахилгааны тогтмол зардлаас женамны зардалд 260.1 мянган төгрөг, цэвэр бохир усны тогтмол зардлаас саван, вок авах зардалд 213.0 мянган төгрөг, томилолтын зардлаас саван, бээлий авах зардалд 271.7 мянган төгрөг нийт 744.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрсэнд аудитаас албан шаардлага хүргүүлсэн.

4. ЭМТ-ийн цалингийн зардлын батлагдсан төсөв гүйцэтгэл, орон тоог тушаал шийдвэртэй тулган шалгах, мөн үр дүнгийн урамшуулалыг Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу олгосон эсэхэд хяналт хийлээ. Хяналтаар сахилгын шийтгэлтэй 5 албан хаагчдад 1,820.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосонд төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ Орон нутгийн төсвийн орлогын талаар:

Орон нутгийн төсвийн орлогыг 96,759.7 мянган төгрөгөөр төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг сумын ИТХурлын 2019.12.13-ний өдрийн 8 тоот тогтоолоор 16,340.9 мянган төгрөгөөр бууруулан 80,418.8 мянган төгрөгөөр анх баталсан байна. Орлого бууруулан баталсан гол шалтгаан нь шууд бус орлогыг 21,460.0 мянган төгрөгөөр бууруулан баталсантай холбоотой байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогыг сумын ИТХурлын 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор 111,043.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Харин гүйцэтгэлээр 174,549.8 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 157.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлангийн хугацаанд газрын төлбөрийн орлого төлөвлөгдөөгүй бөгөөд 701.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 6. Төвлөрүүлэх орлого

/мян. төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	3,600.0	2,951.0	(649.0)	82.0
2	Шууд бус орлого	35,020.0	55,731.1	20,711.1	159.1
3	Хадгаламжийн хүүгийн орлого	36,996.0	50,097.4	13,101.4	135.4
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150.0	2,250.0	2,100.0	1,500.0
5	Бууны татварын орлого	4,920.0	5,010.0	90.0	101.8
6	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	3,300.0	3,431.8	131.8	104.0
7	Газрын төлбөр	-	701.9	701.9	
8	Газрын дуудлага худалдааны орлого	1,500.0	24,346.2	22,846.2	1,623.1
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	930.0	930.1	0.1	100.0
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	5,220.0	5,221.8	1.8	100.0
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	16.8	16.8	-	100.0
12	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	8,000.0	8,007.0	7.0	
13	Ойн нөөц ашигласны төлбөр	9,424.5	10,236.5	812.0	108.6
14	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	96.0	115.0	19.0	119.8

15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	170.0	175.5	5.5	103.2
16	Хүү торгуулийн орлого	1,200.0	4,805.4	3,605.4	400.5
17	Нэр заагдаагүй бусад орлого	500.0	522.3	22.3	104.5
	Дүн	111,043.3	174,549.8	63,506.5	157.2

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч үйл ажиллагааны орлого 649.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь ковид-19 цар тахал гарсантай холбоотой иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг түр хаасан тул үйл ажиллагааны орлогын албан татвар тасрах шалтгаан болсон байна.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. Төсвийн төлөвлөлт

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан мөнгөн дүн	Тодотгон баталсан мөнгөн дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	80,248.8	110,873.3	30,624.5
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	187,882.2	187,882.2	0.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	327,783.3	285,742.8	-42,040.5
4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	63,246.1	60,746.5	-2,499.6
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	2,002,369.8	1,909,130.6	-93,239.2
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	48,000.0	58,116.2	10,116.2
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	81,251.3	81,316.9	65.6
	Нийт дүн	2,790,781.5	2,693,808.5	-96,973.0
Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	57,444.5	57,444.5	0.0
2	Засаг даргын тамгын газар	398,757.6	397,457.8	-1,299.8
3	Орон нутгийн хөгжлийн сан	144,497.4	142,063.4	-2,434.0
4	Сум хөгжүүлэх сан	180,712.2	180,712.2	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	384,174.6	329,774.1	-54,400.5
6	Ерөнхий боловсролын сургууль	1,052,449.9	1,014,765.5	-37,684.4
7	Соёлын төв	92,394.5	92,394.5	0.0
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	480,350.8	479,196.5	-1,154.3
	Нийт дүн	2,790,781.5	2,693,808.5	-96,973.0

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн шууд бус орлогыг 33,400.0 мянган төгрөгөөр нэмж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 1250.0 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 1,373.5 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг 152.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Тодотголоор дараах байгууллагуудын зардлыг хасч баталсан байна. Үүнд:

1. ЗДТГазрын зардлыг 1,299.8 мянган төгрөгөөр,
2. ОНХСангийн зардлыг 2,434.0 мянган төгрөгөөр хассан байна.

Мөн Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн буюу ЕБСургууль, СӨБоловсролын байгууллагын үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор хүүхдийн хоол, үдийн цай болон бусад зардлуудыг нийт 140,903.6 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэл

Батцэнгэл сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 08 тоот тогтоолоор 2,790,781.5 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор ЗДТГ-г 1,299.8 мянган төгрөгөөр, ОНХСанг 2,434.0 мянган төгрөгөөр, СӨБ-г 54,400.5 мянган төгрөгөөр, ЕБС-г 37,684.4 мянган төгрөгөөр, ЭМТөвийг 1,154.3 мянган төгрөгөөр хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг 2,693,808.5 мянган төгрөгөөр баталжээ.

Харин аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС-ийн зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр бууруулж сумын нийт зардлыг 2,691,808.5 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас сургуулийн хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,691,808.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,350,542.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 162,853.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 178,412.2 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,705,400.4 мянган төгрөг буюу 63.4 хувийг улсын төсвөөс, 619,092.8 мянган төгрөг буюу 23 хувийг орон нутгийн төсвөөс, 40,000.0 мянган төгрөг буюу 1.4 хувийг ЭМД-аас, 327,315.3 мянган төгрөг буюу 12.4 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,534,435.7 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь урсгал зардал 54,979.4 мянган төгрөг, хөрөнгийн зардал 19,981.3 мянган төгрөг өөр хэмнэгдсэн, СХСангийн эргэн төлөлт 82,412.2 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХСангийн хөрөнгөөр 8 төсөл, арга хэмжээнд нийт 122,083.1 мянган төгрөг зарцуулагджээ. Үүнд: барилга байгууламжид 45,150.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжид 39,733.1 мянган төгрөг, хогны машинд 37,200.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ахлах сургууль нь төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн ирүүлээгүй, эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлбар тодруулгыг бэлтгээгүй, төсвийн тохируулгын тайланг Сангийн сайдын батлагдсан маягт аргачлалын дагуу гараагүй зөрчилд аудитаас зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах албан шаардлагыг хүргүүлэн ажилласан.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 109.7 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 73,657.1 мянган төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 4,318.6 мянган төгрөг нийт **78,085.4** мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан байна. Үүнээс Эрүүл мэндийн төв 18,932.2 мянган төгрөг, ЗДТГазар 47,939.7 мянган төгрөг, Ахлах сургууль 7,213.6 мянган төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 2,000.0 мянган төгрөг, ИТХурал 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ахлах сургууль нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл аудитаас зөвлөмж хүргүүллээ.
2. ЭМТөв нь Шилэн дансны цахим системд 147 мэдээлэл байршуулахаас хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тухай бүр оруулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар 139,049.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/мянган төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2	139,049.6	1	1,399.6	1	137,650.0	11
Нийт	2	139,049.6	1	1,399.6	1	137,650.0	11

Хүснэгтээс харахад СХСангийн 137,650.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Батцэнгэл сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Батцэнгэл сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл	
	Аудитад хамрагдсан	Үүнээс				Бүгд	Зөрчилгүй
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн			
Ахлах сургууль	1	1				1	1
Хүүхдийн цэцэрлэг	1	1				1	1
ЗДТГ	1				1		
ИТХурал	1	1				1	1
Эрүүл мэндийн төв	1	1				1	1
Соёлын төв	1		1				
ОНХС	1		1				
СХС	1		1				
НИЙТ ДҮН	8	4	3	1		4	4

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 төсөвт байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, соёлын төв, 2 төсөл санг түүвэрт хамруулан, ЗДТГазарт итгэл үзүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 168,746.2 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч 3,137.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 162,067.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 744.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,796.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Үүнээс				Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахлах сургууль	4	0			4	0			1		3	
Хүүхдийн цэцэрлэг	2	32,989.7			2	32,989.7	1	975.4			1	32,014.3
ЗДТГ	0	0			0	0						
ИТХурал	2	0			2	0					2	

Эрүүл мэндийн төв	5	135,756.5	1	3,137.5	4	132,619.0	1	1,820.9	1	744.8	2	130,053.3
Соёлын төв	0	0			0	0						
НИЙТ ДҮН	13	168,746.2	1	3,137.5	12	165,608.7	2	2,796.3	2	744.8	8	162,067.6

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 165,949.9 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 2,796.3 мянган төгрөгийн болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 130,352.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Үүнд: Орон нутгийн орлогын дансанд бүртгэлтэй 3,886.6 мянган төгрөг нь 15-22 жилийн насжилттай эзэн холбогдогчгүй авлагууд байгаа бол, харин 126,466.1 мянган төгрөгийн зөрчил нь СХСангийн чанаргүй зээл байна.

Хүснэгт №11 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/




Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сум хөгжүүлэх сан	1	126,466.1					1	126,466.1				
Нэгдсэн тайлан	2	3,886.6			1	3,886.6	1					
НИЙТ ДҮН	3	130,352.7			1	3,886.6	2	126,466.1				

1. Авлагын бүртгэлийг тулган үзэхэд Сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 243,388.9 мянган төгрөг байгаа бол ч анаргүй зээлийн хэмжээ 126,466.1 мянган төгрөг байна. Аудитаас чанаргүй зээлд зөвлөмж хүргүүллээ.
2. Харин Орон нутгийн орлогод бүртгэлтэй олон жилийн насжилттай эзэн холбогдогчгүй 3,886.6 мянган төгрөгийн авлагад албан шаардлага хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад сум хөгжүүлэх сангийн талаар, болон орон нутгийн орлогын төлөвлөлтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

АУДИТЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн:	Аудитор		Ж.Мөнгөншагай
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор		Д.Уламбаяр

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал:

- 1.1. **Илрүүлэлт:** Авлагын бүртгэлийг тулган үзэхэд Сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 243,388.9 мянган төгрөг байгаа бол 40 иргэнтэй холбоотой 126,466.1 мянган төгрөгийн чанаргүй зээл байна.
- 1.2. **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авах. Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Батцэнгэл сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2021.03.25			АРА-2021/4/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Батцэнгэл сумын ТЕЗ		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Орон нутгийн орлогод бүртгэлтэй олон жилийн насжилттай эзэн холбогдогчгүй 3,886.6 мянган төгрөгийн орлого байна.	3,886.6	Албан шаардлага	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ц.Зоригтхүү Ж.Лхамсүрэн
3	Авлагын бүртгэлийг тулган үзэхэд Сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 243,388.9 мянган төгрөг байгаа бол чанаргүй зээлийн хэмжээ 126,466.1 мянган төгрөг байна	126.466.1	Зөвлөмж өгөх		
	ДҮН	130,352.7			